

Оролцогчдын товч танилцуулга

Жонатан Аддлетон нь 2009 оноос АНУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын албыг хашиж байна. Урьд Пакистан (2006-2007), Камбожи (2004-2006), Монгол (2001-2004) улсуудад АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн (USAID)-ийн захирлаар тус тус ажиллаж байсан. Үүнээс гадна тэрээр Йемен, Иордани, Бельги, Казахстан, Өмнөд Африкт гадаад харилцааны шугамаар удаан хугацааны үүрэгт ажил гүйцэтгэж байсан туршлагатай. Доктор Ж. Аддлетон нь Монголын Нийгэмлэг, мөн TNC (The Nature Conservancy) байгууллагын насан туршийн гишүүн юм. Тэрээр Иллинойс мужийн Нортвестерний их сургуулийг бакалаврын зэрэгтэй төгсөж, Массачусеттс мужийн Тафтсын Их сургуульд магистрын болон докторын зэрэг хамгаалжээ. Ж. Аддлетон Азийн талаар олон нийтлэл, өгүүлэл, мөн "Undermining the Center" (Oxford University Press, 1993), "Some Far and Distant Place" (University of Georgia Press, 2002) нэртэй хоёр ном хэвлүүлэн гаргаад байна.

Ажаа ринбүчи АНУ-ын Индиана муж улсын Блүүмингтон дахь Төвд, Монголын бурханы шашин соёлын төвийн захирал, эдүгээгийн Монголын нэр хүндтэй хутагтуудын нэг юм. Ажаа ринбүчиг хоёр настай байхад нь Х Банчэн Богд Гүмбүм хийдийн ширээт лам, хамба ламын хойд дүрээр тодруулжээ. Хятадын соёлын хувьсгалын үед Ажаа ринбүчийг хүчээр Хятад сургуульд суулган, дараа нь арван зургаан жилийн турш хорих газарт хүнд хүчир ажил хийлгэсэн байна. Соёлын хувьсгалын дараа Ажаа Ринбүчи Гүмбүм хийдийн хамба ламаар ажиллаж эхэлсэн бөгөөд Гүмбүм хийдийг сэргээн засварлах болон хийдийн сургалтыг сэргээх ажлыг хариуцан гүйцэтгэсэн байна. 1998 онд Төвдэд улс төрийн нөхцөл байдал

хурцадсны улмаас Ажаа гэгээн АНУ руу дүрвэн гарсан бөгөөд Калифорни мужид Төвдийн энэрэн нигүүлсэхүй, билиг ухаан төвийг байгуулжээ. 2005 онд Дээрхийн Гэгээн XIV Далай лам түүнийг Индиана мужийн Блүүмингтон хотод орших Төвд, Монголын бурханы шашин, соёлын төвийн захирлаар тохоон томилсон байна.

Мишиг-Ишийн Батаа нь Их Майдар сангийн ахлах зөвлөх, Их Майдар сангийн удирдах зөвлөлийн дэд даргаар ажилладаг. Мөн үүний зэрэгцээ тэрээр Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн гадаад харилцаа эрхэлсэн захирлын албыг хашдаг.

Баатаржавын Бат-Амгалан нь Тод Номун Гэрэл төвийн тэргүүн. 1972 онд Увс аймагт төрсөн Б.Бат-Амгалан 1990 онд дунд сургууль төгсөөд Гадаад хэлний дээд сургууль (хуучин нэрээр Орос хэлний багшийн дээд сургууль)-д элсэн оржээ. Монголд бэлтгэгдсэн анхны англи хэлний багш нарын нэг болсон тэрээр Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн англи хэлний багш, Удирдлагын Академийн гадаад харилцааны ажилтнаар ажиллаж байгаад 1997 оны 4 дүгээр сараас барилга, барилгын материалын үйлдвэрлэл, боловсрол, хэвлэл мэдээлэл зэрэг олон салбарт үйл ажиллагаа явуулдаг, алтны уурхайн тэргүүлэгч “Эрэл” компанид ажиллаж эхэлжээ. Бат-Амгалан “Эрэл” компанид орчуулагч, дараа нь гадаад харилцааны хэлтсийн даргаар 4 жил ажиллаад, 2001 оноос өөрийн бизнесийг эхлүүлсэн юм. Тэрээр оюутан байх үеэсээ эрдэм шинжилгээний ажилд оролцон “Монголчуудын уламжлалт итгэл үнэмшил”, “Уугуул америкчуудын уламжлалт соёл, шашин”, “Монголын залуучуудын боловсролд уламжлалт итгэл үнэмшлийн үзүүлж буй нөлөө” зэрэг судалгааг гүйцэтгэжээ.

2006 оноос тэрээр баруун Монгол судлалд хувь

нэмэр болох зорилготой төрийн бус байгууллага байгуулж, Ойрадын түүх, соёл, шашин, аялгыг судлан, Тод Монгол бичгийн судалгаа, сурталчилгааг идэвхтэй явуулж эхэлжээ. Тэрээр сүүлийн 5 жилд “Тод номун гэрэл” төвийн тэргүүнээр ажиллаж байгаа бөгөөд тус төв нь Монголд төдийгүй олон улсад нэр хүндтэй *Библиотека Ойратика* цувралын хүрээнд 20 ном, *Библиотека Серика* цувралын хүрээнд 4 ном хэвлэн гаргажээ. Тэрээр Монгол болон олон улсын найман хуралд илтгэл тавьж оролцсон юм.

Мигэддоржийн Батчимэг саяхан Монгол улсын Их хурлын гишүүнээр сонгогдсон, өмнө нь Монгол улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын бодлогын зөвлөх ажил үүрэг гүйцэтгэж байв. Тэрээр Монгол улсын Батлан хамгаалахын их сургууль, Тайваны Улс төрийн их сургуульд магистрийн зэрэг хамгаалсан, одоо докторантурт суралцаж буй. Тэрээр бүс нутаг, Монгол улсын үндэсний аюулгүй байдал, Монгол, Хятад улсын харилцааны чиглэлээр судалгаа хийж мэргэшсэн. Батлан хамгаалах яамны харьяа Стратегийн судалгааны хүрээлэнд судлаач, ахлах судлаач, Тайбэй дахь Улаанбаатарын худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газрын тэргүүнээр ажиллаж байсан.

Оохнойн Батсайхан нь Монгол улсын Төрийн шагналт нэрт эрдэмтэн, доктор, профессор бөгөөд Монголын Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын тасгийн эрхлэгчээр ажилладаг. О. Батсайхан ХХ зууны Азийн орчин үеийн олон улсын харилцаа, энэхүү харилцааны Монголтой холбоотой асуудлуудыг онцгойлон сонирхож, түүхэн талаас нь судлан шинжилдэг судлаач юм. Тэрээр мөн Хятад-Оросын нууц харилцааны түүхийг идэвхийлэн судалж байна. Тэрээр XIX зууны сүүл, ХХ зууны эхэн үеийн Монголын олон улсын харилцааны эдэрээтэй

түүхэн асуудлуудын судалгааг хөгжүүлэх зорилго тавин ажиллаж байна. О. Батсайхан Монгол, Орос, Тайван, Герман, Япон, Солонгос, Их Британий архив, номын сангуудад тогтмол очиж судалгаа хийж байна. Тэрээр Японы Тохоку Их сургууль, Их Британий Кембрижийн их сургууль очиж судалгаа хийж байсан туршлагатай. Түүний сүүлийн үеийн судалгааны бүтээлүүд нь: Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба, Адмон, хоёрдахь хэвлэл 2011, 722 тал, УБ; Монголын түүх: үндэстэн улс болсон нь (1911-1946) Адмон, 2005, 350 тал; Монгол хэлээр Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монголын 1915 оны Хиагтын гэрээ. Адмон, 2002, 340 тал, УБ; Коростовецийн өдрийн тэмдэглэл. 1912-1913 онд Монгол сууж байсан Оросын элчин сайд. Эмхэтгэж, эрхэлсэн Олга Бакич, Тацуо Наками. Адмон, 2009. 440 тал, мөн Орос хэл дээр 2010 онд хэвлэгдсэн.

Сандагийн Баянцагаан Арьяабал бурханы номлол бүтээлийн төвийн тэргүүн тэрбээр 1952 онд Ховд аймаг Мянгад сумын нутагт Сандагийн 4 дэхь хүү болж төрсөн. Бага дунд сургуульд суралцаж, 1970 онд цэргийн алба хаагаад 1976 оноос Монголын бурхан шашинтны төв Гандан тэгчилэн хийдийн шашны дээд сургуулийг Бурханы Шашны гүн ухааны судлаач мэргэжлээр суралцаж төгссөн. 1982 оноос Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнд шашин бурханы гүн ухаан судлалаар эрдэм шинжилгээний ажилтнаар ажилласан байна. 1990 оноос Монголын сүсэгтний холбоо олон нийтийн байгууллага байгуулж тэргүүнээр нь 1999 хүртэл ажиллажээ. Монгол оронд 70 гаруй сүм хийдийг сэргээн байгуулахад гар бие оролцсон байна. Одоо Богд Зонховын алдарт Ламрим хэмээх бүтээл дээр тулгуурлан Ламрим дацанг үүсгэн байгуулж тэргүүнээр нь ажиллаж байна. Мөн үүний зэрэгцээ Арьяабал бурханы номлол бүтээлийн төв олон нийтийн байгуулгын тэргүүнээр ажиллаж байна.

Чулуундоржийн Хашчулуун нь Монгол улсын Засгийн газрын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга. Тэрбээр Токиогийн Кэйо их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Монгол улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийн захирал, Япон-Монголын хамтарсан Монголын засгийн газрын дунд хугацааны стратеги төлөвлөлт ба олон нийтийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зөвлөхөөр ажиллаж байсан. Түүний судалгаа, илтгэлүүдээс дурдвал: 2004 онд Нээлттэй нийгэм хүрээлэнгээс хэрэгжсэн “Монгол улсын Эрүүл мэндийн салбарын хувьчлал” судалгааны багийн ахлагч; “Монгол улсын ядууралтай холбогдох эдийн засгийн баримт бичгийн ном зүй” “Монгол улс дахь эдийн засгийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн салбарын 2004 оны илтгэл.

Брюс М. Кнауфт нь “Бүс нутгийн эрсдэлд өртсөн улс орнууд” буюу States at Regional Risk (SARR) төслийн захирал, Самуель Доббсын өргөмжлөл хүртсэн антропологийн профессор бөгөөд АНУ-ын Атланта хот дахь Эмори Их сургуульд ажилладаг. Доктор Б.Кнауфт дэлхийн олон улс орныг хамарсан улс төр-эдийн засаг болон соёлын асуудлуудыг түүхэн хөгжлийн явц, өнөөгийн нөхцөл байдал талаас нь судалдаг. Тэрээр одоо эрсдэлд өртөх магадлалтай дэлхийн улс орнуудын геополитик, эдийн засаг, соёлын нөхцөл байдлыг дэлхийн эдийн засгийн хүчихэг улс орнуудынхтай харьцуулан судалж байна. Тэрээр эрдэм шинжилгээ, судалгаа болон бодит үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, мөн өнөөгийн нийгэм дэхь өөрчлөлт шинэчлэл, сорил бэрхшээлүүдийг онолын талаас нь ойлгон тайлбарлах сонирхол бүхий судлаач хүн юм.

Соёлын антропологичийн мэргэжил эзэмшсэн Б.Кнауфт докторын зэрэг хамгаалахдаа Папуа Шинэ Гвинейн ширэнгэн ойд амьдардаг Гебусу омгийнхны амьдрал, ахуйг хоёр жил судалж байсан бөгөөд одоо ч тэдэнтэй харилцаатай

байгаа ажээ. Эмори их сургуульд 26 жил ажиллах хугацаандаа харьцуулсан судалгааны олон чиглэл бий болгож, янз бүрийн бүс нутаг, судалгааны сэдэв, академик салбаруудыг хамарсан олон төсөл удирдан хэрэгжүүлсэн доктор Б.Кнауфт мөн оюутнуудтай идэвхтэй ажилладаг бөгөөд бакалавр болон докторын түвшний олон курс хичээл зааж, докторын дараах түвшний судалгааны ажил удирдан ажиллаж байна.

Доктор Б.Кнауфт улс төр-эдийн засаг ба соёл, орчин үе ба ялгаварлалт, улс төр ба хүчирхийлэл, жендер ба хүйсийн харьцаа зэрэг сэдвээр долоон ном, олон нийтлэл, өгүүлэлтэй бичиж нийтлүүлээд байгаа юм. Нэмэлт мэдээллийг <http://www.anthropology.emory.edu/FACULTY/ANTBK/> хаягаар орж үзнэ үү.

Пүрэвжавын Лхам Монгол улсын ШУА-ын Түүхийн Хүрээлэнгийн судлаач, Манж Чин улсын захиргаан дахь Халх Монголын бурханы шашны нийгэм хийгээд соёлын хөгжил мөн Монгол улс дахь орчин үежилтийн асуудлаар судалгааны ажил хийдэг. П.Лхам нь *Монголын Бурханы шашны аман түүх* (УБ, 2010), *Нийгэм журмын дараах Монголчууд: XXI зууны эхэн үеийн Монголчуудын амьдралын түүх* (УБ, 2011), *Хүрээ хийдийн жаяг* (УБ, 2011) номын зохиогч, эрхлэн хэвлүүлэгч юм. Тэрээр “Монголын түүх судлал, Хотгойдын Чингүнжав” олон улсын эрдэм шинжилгээний хуралд *Зан үйл болон Чингийн захиргаа: Юунхэгүн болон Долоннуурын хийд рүү лам хувраг илгээх нь* (Улаанбаатар, 2010 оны 7 сарын 19-20), “Антропологи болон нийгмийн ухааны онол” хэмээх эрдэм шинжилгээний хуралд *Монгол судлал дахь антропологийн хандлага (Anthropological Perspectives in Mongolian Studies)* (Чита, ОХУ, 2010 оны 5 сарын 31-нээс 6 сарын 4), Олон улсын Антропологи, Этнологийн XVI их хуралд *XVIII – XIX зууны Монголын өргөлийн зан үйл ба нийгмийн шилжилт хөдөлгөөн (Offering Ritual and Social Mobility in Mongolia in 18-19th*

Centuries) (Кунмин, Хятад улс, 2009 оны 7 сарын 27-30), “Монголын Бурханы шашны судалгааны шинэ чиг хандлага” сэдэвт олон улын эрдэм шинжилгээний бага хуралд *XVIII-XIX зууны Монголын Бурханы шашны сүм хийдийн эдийн засаг, бүтэц, үйл ажиллагаа (Economic Practices of Buddhist Monasteries in Mongolia, 18-19 centuries)* (Оксфордын Их Сургууль, Дорно дахин судлалын хүрээлэн, 2009 оны 5 сарын 6) болон Хятадын хээр талын соёлын форум хэмээх хуралд *Монгол улс дах төвлөрлийн саарал болон социализмийн дараах нийгмийн хэлхээ холбоо (Decentralization and Post-Socialist Networks in Mongolia)* (Хөх хот, Хятад улс, 2008) сэдэвт илтгэл тавьсан.

Глен Х. Муллин бол Төвд судлаач эрдэмтэн, Бурханы шашны сэдвээр бүтээл туурвидаг зохиолч, Төвдийн сонгодог уран зохиол орчуулагч, тарнийн бясалгалын багш хүн юм. Тэрээр ном зохиол бичих, багшлах, бясалгах, Балба, Төвдийн энергийн төвүүдэд жуулчдыг газарчлах зэрэг олон ажлын хуваарьтай амьдардаг.

Глен Төвдийн бурханы шашны тухай хорь гаруй ном бичсэний (Snow Lion Publications, Ithaca, NY хэвлэлийн газар хэвлэн гаргасан) олонхи нь Далай Ламын урьд дүрүүдийн амьдрал, үйл хэрэгт зориулагдсан байдаг. Глен мөн Төвдийн урлаг соёлын хэд хэдэн үзэсгэлэн зохион байгуулж байсан туршлагатай. Эдгээрийн анхных нь болох “Энэрэхүйн урлаг” нэртэй үзэсгэлэнг Шинэ Дели хотын Төвдийн соёлын төвд зохион байгуулагдсан бөгөөд уг үзэсгэлэн хоёр жилийн туршид Европын улс орнуудаар зочлон тавигдаж байжээ. Балба, Төвдийн энергийн төвүүдээр жуулчдад газарчлахын зэрэгцээ Глен эдгээр ариун дагшин газраар бие даан аялах хүсэлтэй хүмүүст аюулгүй байдлаа хэрхэн хангах, газар орны мөн чанарыг нь ухан ойлгох талаар зөвөлгөө өгч тусалдаг байна.

Лхамсүрэнгийн Мөнх-Эрдэнэ одоогоор Лиз Майтнер сангийн тэтгэлгээр Австрийн Шинжлэх ухааны академийн Нийгмийн Антроплогийн хүрээлэнд судалгааны хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тэрээр 2004 онд Японы Хоккайдогийн их сургуульд Түүх, бүс нутаг судлалаар докторын зэрэг хамгаалжээ. 2008-2009 онд Станфордын их сургуулийн Хүмүүнлэгийн ухааны төвд судлаачаар ажиллаж байсан доктор Л. Мөнх-Эрдэнэ нь Монгол Улсын Их сургуулийн профессор юм. Түүний одоо хийж буй “Орчин үеийн Монголын үндэсний ижилсэл” сэдэвт судалгаа нь Монголчуудын үндэстэн ястан, дэд бүлгүүдийн үндэсний ижилсэл буюу ойлголт төрх хэрхэн бүрэлдэж байгаа асуудалд төвлөрч байна. Түүний сүүлийн үед хэвлэн нийтэлсэн бүтээлүүдээс дурьдвал:

“Where did the Mongol Empire come from? Medieval Mongol Ideas of People, State and Empire”, *Inner Asia*, Vol. 13 (2), хэвлэлтийн шатандаа;

“1640 Great Code: An Inner Asian Parallel to the Treaty of Westphalia,” *Central Asian Survey*, 29 (3) 2010;

“Transformation of Mongolia’s Political System: From Semi-parliamentary to Parliamentary?” *Asian Survey*, 50 (2), 2010;

“Beneath the Headless State and Beyond the Aristocratic Orders”, *Ab Imperio*, Vol. 4, 2009;

“Selling of Good Father’s Name: Legitimacy, Pride and Commodity (Commemoration of Chinggis Khan in Modern Mongolia),” *Bulletin* 24, 2008;

“The Mongolian Nationality Lexicon: From the Chinggisid Lineage to Mongolian Nationality (From the seventeenth to early twentieth century),” *Inner Asia*, 8 (1), 2006.

Даниел Мёрфи нь Монтана мужийн их сургуулийн Нийгэм судлал, байгаль хамгааллын тэнхмийн докторын дараах судалгааны хөтөлбөрийн судлаач бөгөөд тэрээр АНУ-ын баруун хэсгийн Роки Маунтин нутгийн ойт бүсээс

амьжиргаагаа залгуулдаг хүн амын уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдал, дасан зохицох чадавхийг судалж байна. Түүний докторын зэрэг горилох диссертаци, мөн сүүлийн үед бичиж нийтлүүлсэн бүтээлүүд нь Монгол дахь нөөц баялагтай холбоотой засаглал, улс төрийн асуудлууд, малчин өрхийн байгалийн гамшигт өртөх эрсдэл зэрэгт төвлөрч байна.

Дамдинжавын Нармандах нь Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Хөдөлмөрийн харилцааны газрын дарга бөгөөд тэрээр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт эдийн засагч, Монголын Хоршоодын холбооны ахлах зохицуулагч, дэд даргаар ажиллаж байжээ.

Цэдэвдамбын Оюунгэрэл нь саяхан Монгол улсын Их хурлын гишүүнээр сонгогдоод байгаа бөгөөд Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүнээр ажилладаг. Тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн орон тооны бус зөвлөхийн албыг хашиж байсан. Төрийн албанд ажилласан арван таван жилийн хугацаанд тэрээр өмч хувьчлал, нийгмийн даатгалын салбарын шинэтгэл зэрэг чухал салбарт ажиллахын зэрэгцээ Ерөнхий сайд, УИХ-ын гишүүний зөвлөх зэрэг хариуцлагатай алба хашиж байсан туршлагатай. Хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх зорилготой “Эрх чөлөө” ТББ-ын үүсгэн байгуулагчдын нэг Ц.Оюунгэрэл нь Монголын нийгэмд ардчилал, жендерийн тэгш байдлыг бэхжүүлэх чиглэлээр тууштай ажилладаг нэр хүндтэй улс төрч юм. Мөн “Орон нутгийн шийдэл” сангийн үүсгэн байгуулагчийн нэг, тэргүүний хувьд тэрээр орчны эрүүл мэндийн асуудлаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд цаг, хүчээ харамгүй зарцуулж байна. Ц.Оюунгэрэл 1997 оноос хойш Монголын Ардчилсан Намын идэвхтэй гишүүн нь юм. Тэрээр Монголд бестселлер болоод байгаа “Америкт суралцсан тэмдэглэл:

АНУ-д суралцах 50 зөвлөгөө” номоо 2007 онд бичиж, мөн ондоо “Нүүдэлчний яриа” номыг хамтран бичсэн байна. 2008 онд Ц.Оюунгэрэлийн хамтран бичсэн “Ногоон нүдэн лам” ном 2008, 2009, 2010 онуудад Монголын шилдэг номоор шалгарч байжээ. 2010 онд тэрээр “Миний ажлын ноу хау” бестселлер номоо бичихийн хажуугаар “*Орчны эрүүл мэндийн тухай иргэний нөхөрлөлийн гарын авлага*” болон ” “*Ажил мэргэжлийн лавлах толь*” нэртэй хоёр гарын авлага орчуулж эмхэтгэн, хэвлүүлээд байна.

Жамсрангийн Пүрэвдорж нь Библийн Сургалтын төвийн захирал, Баярын мэдээ христийн чуулганы пастораар ажилладаг. Чингис овогт Жамсрангийн Пүрэвдорж нь Багшийн сургуулийн хөгжмийн тэнхимд 1990-1992 онуудад багшаар ажиллаж байсан. 1993-1998 онуудад Баярын мэдээ христийн чуулганыг үүсгэн байгуулж, 2003-одоог хүртэл пастораар ажиллаж байна. 1998-2002 онуудад Сингапурын Библийн сургуульд Библийн ухааны магистраар суралцаж дүүргээд, 2003 оноос хойш Улаанбаатар хот дахь Библийн сургалтын төвд багш, хичээлийн эрхлэгчээр ажиллаж эхэлснээс хойш, Библи тайллын ухаан, номлол илтгэлийн үндэс болон теологийн ухааны чухал асуудлуудаар хичээл сургалт хийсэн туршлагатай. Ж.Пүрэвдорж нь Христийн сургаалыг Монголд түгэн дэлгэрэхэд гар бие оролцсон анхны христ итгэгчдийн төлөөлөл юм. Одоогоор Монгол улсын их сургуулийн шашны тэнхимд докторантурт суралцаж байна.

Рустам Сабиров нь 2004 онд Москвагийн улсын их сургуулийн Ази, Африкийн судалгааны хүрээлэнд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд одоо тус сургуульд ахлах судлаачаар ажиллаж байна. Тэрээр “Монгол дахь шашны нөхцөл байдал: 1980 оны сүүл үеэс 2000 он хүртэлх” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. 2005 оноос хойш доктор

Р. Саби́ров нь Монголын түүх, Монголын шашны түүх, Олон улсын харилцаанд Монгол улс болон Монголын угсаатан зүй зэрэг хичээлийг Москвагийн Улсын Их Сургуулийн Ази, Африкийн Судалгааны Хүрээлэнд зааж байна. Рустам Саби́ров эдүгээ үеийн Монголын шашны асуудлуудаар судалгаа хийдэг.

Дэвид Снийт нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны малчин өрхүүдийн дунд гарч байгаа нийгэм, эдийн засаг, улс төрийн өөрчлөлтүүдийг судлан 1991 онд Кембрижийн их сургуульд докторын зэрэг хамгаалжээ. Тэрээр 1994 Британийн Шинжлэх Ухааны академийн докторын дараах судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт шалгарснаар Монгол болон Өвөр Азийн байгаль орчин, нийгмийн асуудлаарх судалгаагаа үргэлжлүүлэх боломжтой болсон юм. 1998 онд доктор Снийт Оксфордын Их сургуулийн Антропологи, Хөгжлийн тэнхимд багшаар ажиллаж байгаад, 2000 онд Кембрижийн их сургуульд эргэн ирж, Нийгмийн Антропологийн тэнхимд багшлахын зэрэгцээ Монгол болон Өвөр Азийн Судалгааны нэгжийн захирлаар ажиллаж байгаад, 2009 оноос тэнхмийнхээ эрхлэгчээр томилогдон ажиллаж байна.

Рик Таупиер нь Амхерст дахь Массачусеттсийн их сургуулийн эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал юм. Тэрээр Массачусеттсийн их сургуульд байгаль орчны эдийн засгийн асуудлаар магистрийн зэрэг, дараа нь бүс нутгийн байгаль орчны төлөвлөлтийн асуудлаар докторын зэрэг хамгаалсан. Эдүгээ доктор Таупиер нь түүхийн ухаанаар докторын зэрэг горилон Төв Азийн бурханы шашны соёл, түүний дотор Монгол, Төвдийн улс төр, соёлын түүхийг судалж байна. Тэрээр Ойрад Монголчууд бурханы шашныг хүлээн авч, улмаар бурханы сургаал номлол Монгол болон Ойрад Монголын улс төрд хэрхэн нөлөөлсөн талаар өргөн цар хүрээний судалгааны ажил хийж байна. Түүний судалгааны

хүрээнд байгаль орчин, соёлын тогтвортой байдлын асуудал багтаж явдаг тул сүүлийн жилүүдэд доктор Таупиер мөн Монгол малчдын тогтвортой амьжиргааны талаар судалгаа хийж байна. 2009 онд Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийн ахлах судлаачаар шалгарсан доктор Таупиер 2009-2010 онд Монгол улсын их сургуульд ажилласан юм.

Кристина Телеки нь Өтвөш Лоранд Их сургуульд Төвд, Монгол судлалаар магистр, дараа нь 2009 онд докторын зэрэг хамгаалжээ. Тэрээр Монголын шашны төв болон хуучны сүм, хийдүүдийг судалж докторын зэрэг горилох бүтээлээ туурвиж байсан бол одоо ч энэ сэдвээрээ үргэлжлүүлэн судалгаа хийж байна. К.Телеки Монголын бурханы шашин өнгөрсөн болон өнөө үеийн холбогдолтой архивын материал судлах, аман түүхийг баримтжуулан тэмдэглэх, сүм хийдийн туурийг судлах, лам хуврагуудын өнөөдрийн амьдралыг ажиглах зорилгоор 1999 оноос хойш Монголд 7 удаа иржээ. Судалгаандаа үндэслэн түүний бичиж хэвлүүлсэн бүтээлүүдээс дурьдвал:

On the Current Condition of 190 Old and Present-Day Monastic Sites in the Mongolian Countryside, *Zentralasiatische Studien*, Bonn 2011, pp. 93-140

Building on ruins, memories and persistence: Revival and survival of Buddhism in the countryside, In: *Silk Road 7*, Seattle 2009, pp. 64-73. (also http://www.silkroadfoundation.org/newsletter/vol7/srjournal_v7.pdf); Origin and Spread of Buddhism in Buryatia: A Text of Buyandalai dooramba, In: *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae* (AOH) 61 (2008), Budapest, pp. 521-541
Нийслэл хүрээнд байсан сүм, хийдүүд (Monasteries existed once in Niislel khγree), *Lam nariin setgьyl 4.*, Ulaanbaatar, pp. 86-94.; Лам нарын сэтгүүлийн 1936 онд анх гарсан дугаар (The first volume of the Journal of the Lamas, published in 1936), Лам нарын сэтгүүл 4, Улаанбаатар, 193-199 дүгээр нүүр; www.mongoliantemples.net

Доржийн Түвшинтөгс нь Монголын хааны бөө бөгөөд Монголчуудын өвөг дээдсийн бөөгийн уламжлалыг сэргээхийг зорин ажиллаж буй нэгэн билээ. Түүнийг шүтэж, зөвлөгөө, тусламж авдаг олон хүн байдаг.

Весна Уоллис Санта Барбара дахь Калифорнийн их сургуулийн Шашин судлалын тэнхимийн профессор бөгөөд тэрбээр 1995 онд Беркелийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан, Энэтхэгийн Их хөлгөний бурханы шашин, Монголын бурханы шашныг судалдаг. Тэрбээр Оксфордын их сургуулийн Ехан Нумата бурханы шашны судалгааны төвийн захирлаар ажиллаж байжээ. Весна Уоллис дөрвөн ном, олон арван өгүүлэл нийтлүүлснээс саяхны бүтээл нь *Цогц цагийн хүрдний үндэс: Садхана Вималапрабха* бүлэг. Мөн тэрээр Санскрит, Төвд хэлнээс Бодсадын замд орохуй номыг орчуулсан (*A Guide to the Bodhisattva Way of Life*. Translated from Sanskrit and Tibetan by Vesna A. Wallace and B. Alan Wallace, Ithaca, NY: Snow Lion Publications, 1997) бөгөөд эдүгээ Бурханы шашин Монголын түүх, нийгэм, соёлд хэмээх бүтээл дээр ажиллаж байна.